

2025年「伊勢」と日本スタディプログラム 最終レポート

神道を通じて感じる日本人の心の美学

神道とは何か？ 神道は日本の伝統的な信仰であり、日本の成り立ちや天皇、祖先と深く結びついています。宗教というよりも、日本人の心、文化、生活の一部といえるでしょう。そのため、日本人に「どの宗教を信仰していますか？」と尋ねると、「無宗教です」と答える人も多いかもかもしれません。しかし、神道はその存在を目立たせることなく、日本人の生活に溶け込み続けているのです。

神道は2000年以上の歴史を持ち、「神社」と呼ばれる神聖な場所で、多くの神々が祀られています。神道では太陽、山、川、さらには漬物の神まで存在するとされます。すべてに神が宿ると考えれば、自ずと物や自然を大切にし、他人を敬う心が芽生えるのではないのでしょうか。日本人が環境を大切にし、人に迷惑をかけないようにするのも、この精神から来ているのかもしれない。

神社を訪れた際は、神職の作法をぜひ観察してみてください。一つ一つの動作には決まりがあり、心を込めて行われています。特別なことをしているわけではありませんが、毎日の行為に常に心を込めることは簡単ではないと思います。時には怠けたくなることもあるでしょう。それでも日々の務めを丁寧にこなし、伝統を守り続ける姿勢は、日本人の精神性そのものだと感じました。この規律の厳格な継承こそが、千年以上変わらぬ伝統を守り続ける力なのかもしれません。日本人の生活の中にも、この「一つのことを徹底する姿勢」や「決まりを守る精神」は深く根付いていると感じます。日本には「継続は力なり」という言葉があります。継続することは、力だけではなく、人生に意味を与える美学でもあると考えます。

神職の作法を見ていると、彼らは「責任を果たすこと」に大きな誇りを持っているようにも思えました。この姿勢は天皇の役割にも強く表れています。例えば、6世紀から13世紀までの約660年間、天皇の血を引く未婚の女性が「斎王」として伊勢神宮に仕え、一生を神に捧げていたそうです。また、明治天皇は「天皇には『わたくし』はない」と述べられたそうです。これは、天皇は個人的な欲望を持つのではなく、国家と国民のために存在するべきという考え方を示しています。こうした例からも、日本人が個人の願望よりも、果たすべき責任を重視する価値観を持っていることがわかります。こ

の精神は、義務や役割を忠実に守ることに美しさを見出す日本独自の文化であり、非常に感銘を受けています。

神道と日本文化について学ぶために伊勢に過ごしたこの3週間だけでは日本人の心を完全に説明することはできません。しかし、神道は単なる宗教ではなく、伝統文化としての日本人の心の表れであることを実感しました。だからこそ、神道の中心地である伊勢、伊勢神宮は「日本人の心の故郷」と呼ばれているのだと思います。ここで得られた経験や気づきをさらに深め、日本人の精神や価値観をより深く理解するために、これからも学び続けたいと思います。

最後に、この素晴らしいプログラムを企画してくださった伊勢市の関係者の皆様、皇學館大学の先生方や学生方、スタッフの皆様に心から感謝し、今後のさらなるご発展をお祈り申し上げます。

2025 “Ise” and Study Program Final Report

Япон хүний зүрх сэтгэлд шинто шашнаар дамжих гоо зүй

Шинто шашин гэж юу вэ? Энэ бол Японы уламжлалт шашин бөгөөд Япон улс хэрхэн үүсэж бий болсон төдийгүй Японы эзэн хаан болон түүний өвөг дээдэстэй салшгүй холбоотой зүйл юм. Шинто нь шашин гэхээсээ илүү Япон улс, Япон хүний зүрх сэтгэл, уламжлалт соёл, амьдралын хэв маягийн нэг хэсэг гэж хэлж болох юм. Тиймээс та Япон хүнээс та ямар шашин шүтдэг вэ гэж асуухад “Би шүтлэггүй” гэж хэлж магадгүй ч, шинто өөрийн дүр төрхөө харуулахгүй ч Япон хүмүүсийн амьдралын салшгүй нэг хэсэг болон оршоор байдаг.

Шинто шашин 2,000 гаран жилийн түүхтэй. “Жинжа” гэж хэлэгддэг Шинто шашны сүмд олон янзын бурхдыг залсан байдаг. Нар, уул, ус, бүр дарсан ногооны бурхан хүртэл байдаг. Би энд бүх зүйлд бурхан үнэхээр оршдог эсэхийг мэтгэлцэх гэсэнгүй. Гэвч бүх зүйлд бурхан оршдог гэж та итгэвэл тэр бүхэнд хүндэтгэлтэй хандахгүй гэж үү? Өөрийн эдэлж хэрэглэдэг юмнаас гадна, байгаль орчноо хайрлан гамнаж, бусдын өөрийн гэлтгүй хүндэтгэлтэй хандах сэтгэл өөрийн эрхгүй төрөхгүй гэж үү? Энэ л сэтгэлгээнээс Япон хүн яагаад бусдад төвөг удахыг хүсдэггүй, байгаль орчиндоо гамтай ханддагийг ойлгож болох юм.

Жинжад зочилбол та санваартнуудын зан үйлийг заавал харж үзэхийг зөвлөж байна. Тэнд та санваартнуудын үйлдэл бүр дэг жаягтай бөгөөд чин сэтгэлээсээ хийж буй дүр төрхийг олж харах болно. Тэрхүү төгс төгөлдөр үйлдлүүдэд гэхдээ ямар ч онцгой зүйл байхгүй. Тэдний өдөр тутамдаа хийдэг л зан үйлүүд юм. Гэхдээ бодоод үзвэл хүн байнга хийдэг зүйлдээ үргэлж сэтгэл зүрхээ шингээн үйлдэнэ гэдэг хэцүү биш гэж үү? Хааяа нэг удаа ч болов залхуурах, хайнга хандах үе байхгүй гэж үү? Тиймэрхүү сэтгэлзүйн мөчүүдэд өөрийгөө барьж дэг жаягаа чанд мөрдөн, чин сэтгэлээсээ хандах, энэ л санваартнуудын сэтгэл санааны хүч, итгэл үнэмшлийн илэрхийлэл гэж би бодсон юм. Энэхүү сэтгэлзүй тэр чигтээ Япон хүний зүрх сэтгэлд шингэн, ямар нэг ажлыг сэтгэлээсээ хийх, дэг жаягийг чандлан дагадаг мэт санагдлаа. Бүр цааш нь бодоод үзвэл дэг жаягийг яг таг дагахгүй бол түүнийг хэдэн мянган жил тэр хэвээр нь хадгалан авч үлдэх боломжгүй гэж мөн санагдсан юм. Энэхүү сэтгэлгээг бид Япон хүний амьдралын хэв маягаас хөнгөхөн ажиглаж болно. Нэг зүйлдээ тууштай байж, дүрэм журмыг чандлан дагах хандлага юм.

Японд “Тууштай байдал бол нэг төрлийн чадвар” гэж үг байдаг. Тууштай байдал чадвар төдийгүй амьдралд утга учир өгдөг гоо зүй гэж дээрхээс дүгнэж болох юм.

Нөгөө талаас авч үзвэл санваартнууд өөрсдийн хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх гэсэн хариуцлагыг маш чухалд авч үздэг юм шиг санагдсан. Энэхүү хандлага ялангуяа эзэн хааны гэр бүлээс маш хүчтэй мэдрэгдсэн. Жишээ нь: Японд 6-р зуунаас 13-р зуун хүртэл 660 жилийн турш эзэн хааны удмаас сонгогдсон Сайо гэж нэрлэгдэх гэрлээгүй бүсгүй бурхны сүмд байршин нэг насаа зөвхөн бурханд үйлчлэхэд зориулдаг байсан байна. Мөн Мэйжи үеийн эзэн хаан “Эзэн хаанд би гэж үг байдаггүй” гэж хэлсэн байдаг. Энэ нь эзэн хаан бол өөрийн хүсэл сонирхол буюу “Би”-г бодох эрхгүй ба зөвхөн улс орон, ард түмний төлөө өөрийгөө зориулах ёстой гэсэн үзэл бодол юм. Дээрх жишээнүүд нь үүрэг хариуцлагаа өөрийн хүсэл сонирхлоос илүүд тавих үзэл санааг илэрхийлж буй бөгөөд надад маш үзэсгэлэнтэй санагдсан гэдгийг онцолмоор байна.

“Би” юу хиймээр байгаа, юу хүсэж байгаагаас илүүтэйгээр “Би” яах ёстой вэ, миний үүрэг хариуцлага юу гэдгийг ухамсарлаж түүндээ үнэнч байна гэдэг Япон хүний зүрх сэтгэлд эрт үеийн ёс уламжлал, амьдралын хэв маягтай хамт хоногшин нь ийм учиртай гэж бодож байна.

Шинто шашнаар дамжин Япон хүний зүрх сэтгэл хэрхэн бий болсныг хэдхэн үгээр ийнхүү дүгнэх боломжгүй ч, Исэ хотод өнгөрүүлсэн хугацаандаа Шинто шашин нь шашин гэхээс илүү Япон хүний зүрх сэтгэлийн илэрхийлэл болон оршиж байдаг, тийм ч учраас Шинто шашны төв болсон Исэ хот, Исэ жингү нь Япон хүний зүрх сэтгэлийн эх орон гэж хэлэгддэг болохыг бага ч болов ойлгож чадсан гэж найдаж байна. Энд олж авсан туршлага, мэдрэмжээ цаашид илүү хурцалж, Японы хүнийг илүү танин мэдэхийн төлөөх хичээх болно.

Эцэст нь энэхүү гайхалтай программыг зохион байгуулсан Исэ хотын удирдлага болон Когакан их сургуулийн багш, хамт олонд чин сэтгэлийн талархлаа илэрхийлж, цаашдын ажил үйлсэд нь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе.